

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



### САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Говь-Алтай аймгийн Гуулин тосгоны Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ГАА-2022/46/-НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Алтай хот 2022 он	Дарга, Тэргүүлэх аудитор: Х.Түвшинбаяр Утас: 70483413 Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг Утас: 70484055 Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn Ахлах аудитор: Ж.Бүжинханд Утас: 99177546 Цахим хаяг: Bujinkhandj@audit.gov.mn Аудитор: Б.Цэвэлмаа Утас:99026016 Цахим хаяг: Tsevelmaab@audit.gov.mn
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	8
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	9
3. Аудитын тайлан .....	11
3.1 Ерөнхий зүйл.....	11
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .....	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	11
3.4 Материаллаг байдал .....	12
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга .....	12
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	13
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	14
3.8 Аудитын гол асуудал .....	14
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	14
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	14
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	14
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	14
4. Аудитын илрүүлэлт .....	15
4.1 Залруулсан алдаа .....	15
4.2 Төлбөрийн акт.....	15
4.3 Албан шаардлага .....	15
4.4 Зөвлөмж.....	16
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	16

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт



## ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

9018301, Говь-Алтай аймаг,  
Есөнбулаг сум, 7-р баг, Жинст 0  
Утас: 70-48-34-13. Факс: (976) 70-48-34-13,  
E-mail: govialtai@audit.gov.mn

2022. 02. 22 № 04

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

### Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Говь-Алтай аймгийн Дэлгэр сумын Гуулин тосгоны Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Говь-Алтай аймгийн Дэлгэр сумын Гуулин тосгоны Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Шатахууныг анхан шатны баримтгүй, жолоочийн тооцооны хуудасгүй зарцуулсан, жилийн эцсийн хөрөнгийн тооллогын дүн санхүүгийн тайлангаас зөрүүтэй, нягтлан бодогч тооцоо бодоогүй, татварын тодорхойлолтоор илүү, дутуу төлөлт татварын цахим системд бүртгэлтэй, зардлын эдийн засгийн ангилал зөрчсөн зэрэг 14.2 сая төгрөгийн зөрчлүүд нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаал, АДБОУС 1250, 1300, MNS-6817-4:2020 стандартын 7.1.2.2, 7.1.3.4 заалт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна гэж заасныг зөрчсөн, үнэн зөв байх, толилуулга ба тодруулга, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

07020043

## Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага


Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Х.ТҮВШИНБАЯР



## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>14,414,451.50</b>	<b>76,388,398.68</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	<b>0.00</b>	<b>12,966,950.43</b>
<b>31200</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	<b>0.00</b>	<b>12,966,950.43</b>
<b>31210</b>	<b>Төгрөг</b>	<b>0.00</b>	<b>12,966,950.43</b>
31211	Төрийн сангийн харилцах	0.00	12,966,950.43
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	<b>0.00</b>	<b>52,610,000.00</b>
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	0.00	52,610,000.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>14,414,451.50</b>	<b>10,811,448.25</b>
<b>35100</b>	<b>Түүхий эд материал</b>	<b>6,896,100.50</b>	<b>7,478,853.25</b>
35130	Эм боох материал	6,896,100.50	7,478,853.25
<b>35400</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>7,518,351.00</b>	<b>3,332,595.00</b>
35410	Бичиг хэргийн материал	222,500.00	0.00
35420	Аж ахуйн материал	56,000.00	0.00
35440	Түлш, шатах тослох материал	513,231.00	0.00
35460	Хүнсний материал	2,272,320.00	1,005,795.00
35470	Бусад хангамжийн материал	4,454,300.00	2,326,800.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>298,039,151.77</b>	<b>308,280,097.36</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>298,039,151.77</b>	<b>308,280,097.36</b>
<b>39200</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>293,735,151.77</b>	<b>303,976,097.36</b>
39201	Барилга, байгууламж, орон сууц	293,200,346.39	293,200,346.39
39202	Хуримтлагдсан элэгдэл	-26,722,364.80	-33,597,471.19
39203	Авто-тээврийн хэрэгсэл	29,736,434.00	29,736,434.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-14,868,217.08	-18,585,271.35
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	85,399,051.11	103,589,032.67
39206	Хуримтлагдсан элэгдэл	-77,442,271.03	-73,993,887.01
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	20,564,255.00	20,309,355.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-16,132,081.82	-16,682,441.15
<b>39300</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>4,304,000.00</b>	<b>4,304,000.00</b>
39301	Програм хангамж	600,000.00	600,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-600,000.00	-600,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	4,304,000.00	4,304,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>312,453,603.27</b>	<b>384,668,496.04</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>0.00</b>	<b>22,133,505.00</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>0.00</b>	<b>22,133,505.00</b>
<b>41300</b>	<b>Өглөг</b>	<b>0.00</b>	<b>22,133,505.00</b>
<b>41360</b>	<b>Бусад өглөг</b>	<b>0.00</b>	<b>22,133,505.00</b>
41361	Байгууллагад төлөх өглөг	0.00	22,133,505.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>312,453,603.27</b>	<b>362,534,991.04</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>312,453,603.27</b>	<b>362,534,991.04</b>
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	334,431,867.89	334,431,867.89
<b>51200</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>-185,951,768.67</b>	<b>-135,870,380.90</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	-167,905,590.02	-185,951,768.67
51220	Тайлант үеийн үр дүн	-18,046,178.65	50,081,387.77
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	163,973,504.05	163,973,504.05
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>312,453,603.27</b>	<b>384,668,496.04</b>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>294,702,268.00</b>	<b>470,553,691.72</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>10,637,666.00</b>	<b>90,669,774.72</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>10,637,666.00</b>	<b>90,669,774.72</b>
<b>120004</b>	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	<b>10,637,666.00</b>	<b>0.00</b>
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	10,637,666.00	0.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	0.00	21,327,115.56
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	0.00	69,342,659.16
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>284,064,602.00</b>	<b>379,883,917.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>256,134,800.00</b>	<b>288,735,200.00</b>
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	256,134,800.00	288,735,200.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>8,419,382.00</b>	<b>75,241,057.00</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	8,419,382.00	22,631,057.00
131107	Эрүүл мэндийн даатгалын сангийн нэмэлт орлого	0.00	52,610,000.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>12,541,000.00</b>	<b>14,141,000.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	12,541,000.00	14,141,000.00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	<b>6,969,420.00</b>	<b>1,766,660.00</b>
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	6,969,420.00	1,766,660.00
<b>II</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>301,936,165.26</b>	<b>418,313,637.95</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>301,936,165.26</b>	<b>418,313,637.95</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>297,634,450.95</b>	<b>393,823,444.16</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>182,992,765.69</b>	<b>204,859,330.81</b>
210101	Үндсэн цалин	116,124,535.12	139,699,637.33
210102	Нэмэгдэл	51,740,231.60	35,902,990.92
210103	Унаа хоолны хөнгөлөлт	2,950,746.00	2,812,000.00
210104	Урамшуулал	12,177,252.97	12,050,885.38
210105	Гэрээт ажлын хөлс	0.00	14,393,817.18
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>24,597,000.00</b>	<b>27,623,130.06</b>
210201	Тэтгэврийн даатгал	17,309,000.00	19,495,333.97
210202	Тэтгэмжийн даатгал	1,822,000.00	2,046,184.79
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,463,600.00	1,636,906.89
210204	Ажилгүйдлийн даатгал	358,400.00	404,036.56
210205	Эрүүл мэндийн даатгал	3,644,000.00	4,040,667.85
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>11,113,768.00</b>	<b>13,777,206.21</b>
210301	Гэрэл, цахилгаан	1,422,268.00	1,617,680.15
210302	Түлш, халаалт	9,492,500.00	11,960,526.06
210303	Цэвэр, бохир ус	199,000.00	199,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>11,268,462.00</b>	<b>15,255,219.00</b>
210401	Бичиг хэрэг	776,700.00	1,061,000.00
210402	Тээвэр, шатахуун	7,680,112.00	12,684,419.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	999,250.00	868,300.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	659,300.00	96,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,153,100.00	545,500.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>20,227,421.50</b>	<b>115,500,181.11</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	13,854,001.50	104,652,810.41
210502	Хоол, хүнс	4,578,420.00	9,075,375.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,795,000.00	1,771,995.70
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>1,522,500.00</b>	<b>1,411,400.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	522,500.00	403,000.00
210604	Урсгал засвар	1,000,000.00	1,008,400.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>900,000.00</b>	<b>1,198,057.00</b>

210702	Дотоод албан томилолт	900,000.00	1,198,057.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>23,087,499.00</b>	<b>468,950.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	22,049,999.00	0.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	437,500.00	0.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	0.00	33,000.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	200,000.00	0.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	400,000.00	435,950.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>21,925,034.76</b>	<b>13,729,969.97</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,661,300.00	1,053,800.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	18,263,734.76	12,676,169.97
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>4,301,714.31</b>	<b>24,490,193.79</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>4,228,782.00</b>	<b>22,996,800.00</b>
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	3,628,782.00	0.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	600,000.00	22,996,800.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>72,932.00</b>	<b>1,493,393.79</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	72,932.00	1,493,393.79
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</b>	<b>-7,233,897.26</b>	<b>52,240,053.77</b>
<b>V</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>10,812,281.39</b>	<b>2,158,666.00</b>
225001	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз	10,812,281.39	0.00
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	0.00	2,158,666.00
<b>VI</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)</b>	<b>-18,046,178.65</b>	<b>50,081,387.77</b>

### 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	334,431,867.89	163,973,504.05	-167,905,590.02	330,499,781.92
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	334,431,867.89	163,973,504.05	-167,905,590.02	330,499,781.92
Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-18,046,178.65	-18,046,178.65
2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	334,431,867.89	163,973,504.05	-185,951,768.67	312,453,603.27
2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	334,431,867.89	163,973,504.05	-185,951,768.67	312,453,603.27
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	334,431,867.89	163,973,504.05	-185,951,768.67	312,453,603.27
Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	50,081,387.77	50,081,387.77
2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	334,431,867.89	163,973,504.05	-135,870,380.90	362,534,991.04

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>284,064,602.00</b>	<b>327,273,917.00</b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>284,064,602.00</b>	<b>327,273,917.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>256,134,800.00</b>	<b>288,735,200.00</b>
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	256,134,800.00	288,735,200.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>8,419,382.00</b>	<b>22,631,057.00</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	8,419,382.00	22,631,057.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>12,541,000.00</b>	<b>14,141,000.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	12,541,000.00	14,141,000.00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	<b>6,969,420.00</b>	<b>1,766,660.00</b>
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	6,969,420.00	1,766,660.00
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>278,967,102.00</b>	<b>312,716,966.57</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>278,967,102.00</b>	<b>312,716,966.57</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>274,665,387.69</b>	<b>288,226,772.78</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>182,992,765.69</b>	<b>204,859,980.81</b>
210101	Үндсэн цалин	116,124,535.12	139,664,637.33
210102	Нэмэгдэл	51,740,231.60	35,902,990.92
210103	Унаа хоолны хөнгөлөлт	2,950,746.00	2,812,000.00
210104	Урамшуулал	12,177,252.97	12,050,885.38
210105	Гэрээт ажлын хөлс	0.00	14,429,467.18
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>24,597,000.00</b>	<b>27,623,130.06</b>
210201	Тэтгэврийн даатгал	17,309,000.00	19,495,333.97
210202	Тэтгэмжийн даатгал	1,822,000.00	2,046,184.79
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,463,600.00	1,636,906.89
210204	Ажилгүйдлийн даатгал	358,400.00	404,036.56
210205	Эрүүл мэндийн даатгал	3,644,000.00	4,040,667.85
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>11,468,068.00</b>	<b>11,649,706.21</b>
210301	Гэрэл, цахилгаан	1,422,268.00	1,617,680.15
210302	Түлш, халаалт	9,846,800.00	9,833,026.06
210303	Цэвэр, бохир ус	199,000.00	199,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>11,501,093.00</b>	<b>14,559,988.00</b>
210401	Бичиг хэрэг	999,200.00	699,500.00
210402	Тээвэр, шатахуун	8,193,343.00	12,171,188.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	999,250.00	868,300.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	659,300.00	321,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	650,000.00	500,000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>14,935,162.00</b>	<b>23,165,260.70</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	7,640,162.00	16,302,045.00
210502	Хоол, хүнс	5,500,000.00	5,063,220.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,795,000.00	1,799,995.70
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>1,132,500.00</b>	<b>3,213,900.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	132,500.00	2,216,000.00
210604	Урсгал засвар	1,000,000.00	997,900.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>900,000.00</b>	<b>1,198,057.00</b>
210702	Дотоод албан томилолт	900,000.00	1,198,057.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>23,087,499.00</b>	<b>642,950.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	22,049,999.00	0.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	437,500.00	0.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	0.00	33,000.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	200,000.00	0.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	400,000.00	609,950.00

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4,051,300.00	1,313,800.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,051,300.00	1,313,800.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4,301,714.31	24,490,193.79
2132	Бусад урсгал шилжүүлэг	4,228,782.00	22,996,800.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	3,628,782.00	0.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	600,000.00	22,996,800.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	72,932.00	1,493,393.79
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	72,932.00	1,493,393.79
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	5,097,500.00	14,556,950.43
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	5,097,500.00	1,590,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	5,097,500.00	1,590,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	5,097,500.00	1,590,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	5,097,500.00	1,590,000.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-5,097,500.00	-1,590,000.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	0.00	12,966,950.43
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	12,966,950.43

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	Цэвэр гүйцэтгэл	Төсвийн хэмнэлт+, хэмнэлт-	Хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	310,272,400.0	290,182,515.78	20,089,884.22	94%
21	УРСГАЛ ЗАРДАЛ	310,272,400.0	290,182,515.78	20,089,884.2	94%
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	309,672,400.0	289,589,715.78	20,082,684.2	94%
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	220,000,000.0	204,859,980.81	15,140,019.2	93%
210101	Үндсэн цалин	151,700,000.0	139,664,637.33	12,035,362.7	92%
210102	Нэмэгдэл	35,000,000.0	35,902,990.92	(902,990.9)	103%
210103	Унаа хоолны хөнгөлөлт	3,000,000.0	2,812,000.00	188,000.0	94%
210104	Урамшуулал	12,300,000.0	12,050,885.38	249,114.6	98%
210105	Гэрээт ажлын хөлс	18,000,000.0	14,429,467.18	3,570,532.8	80%
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	29,700,000.0	27,623,130.06	2,076,869.9	93%
210201	Тэтгэврийн даатгал	20,900,000.0	19,495,333.97	1,404,666.0	93%
210202	Тэтгэмжийн даатгал	2,200,000.0	2,046,184.79	153,815.2	93%
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,760,000.0	1,636,906.89	123,093.1	93%
210204	Ажилгүйдлийн даатгал	440,000.0	404,036.56	35,963.4	92%
210205	Эрүүл мэндийн даатгал	4,400,000.0	4,040,667.85	359,332.2	92%
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	13,141,000.0	11,649,706.21	1,491,293.8	89%
210301	Гэрэл, цахилгаан	3,094,200.0	1,617,680.15	1,476,519.9	52%
210302	Түлш, халаалт	9,846,800.0	9,833,026.06	13,773.9	100%
210303	Цэвэр, бохир ус	200,000.0	199,000.00	1,000.0	100%
2104	Хангамж, бараа материалын зардал	14,572,200.0	14,559,988.00	12,212.0	100%
210401	Бичиг хэрэг	700,000.0	699,500.00	500.0	100%
210402	Тээвэр, шатахуун	12,172,200.0	12,171,188.00	1,012.0	100%
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	700,000.0	868,300.00	(168,300.0)	124%

210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	500,000.0	321,000.00	179,000.0	64%
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	500,000.0	500,000.00	-	100%
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>23,537,700.0</b>	<b>23,165,260.70</b>	<b>372,439.3</b>	<b>98%</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	16,337,700.0	16,302,045.00	35,655.0	100%
210502	Хоол, хүнс	5,400,000.0	5,063,220.00	336,780.0	94%
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,800,000.0	1,799,995.70	4.3	100%
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>4,815,700.0</b>	<b>4,803,900.00</b>	<b>11,800.0</b>	<b>100%</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	3,815,700.0	3,806,000.00	9,700.0	100%
210604	Урсгал засвар	1,000,000.0	997,900.00	2,100.0	100%
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>1,292,000.0</b>	<b>971,000.00</b>	<b>321,000.0</b>	<b>75%</b>
210702	Дотоод албан томилолт	1,292,000.0	971,000.00	321,000.0	75%
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>1,300,000.0</b>	<b>642,950.00</b>	<b>657,050.0</b>	<b>49%</b>
210804	Тээврийн хэрэгслийн татвар	40,000.0	33,000.00	7,000.0	83%
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	610,000.0	609,950.00	50.0	100%
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>1,313,800.0</b>	<b>1,313,800.00</b>	<b>-</b>	<b>100%</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,313,800.0	1,313,800.00	-	100%
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>600,000.00</b>	<b>592,800.00</b>	<b>7,200.00</b>	<b>99%</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>600,000.0</b>	<b>592,800.00</b>	<b>7,200.0</b>	<b>99%</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	600,000.0	592,800.00	7,200.0	99%
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>310,272,400.0</b>	<b>303,149,466.21</b>	<b>7,122,933.8</b>	<b>98%</b>
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>288,735,200.0</b>	<b>288,735,200.00</b>	<b>-</b>	<b>100%</b>
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	288,735,200.0	288,735,200.00	-	100%
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>14,141,000.0</b>	<b>12,647,606.21</b>	<b>1,493,393.8</b>	<b>89%</b>
132001	Орон нутгийн төсвөөс	14,141,000.0	12,647,606.21	1,493,393.8	89%
<b>1340</b>	<b>НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>7,396,200.0</b>	<b>1,766,660.0</b>	<b>5,629,540.0</b>	<b>24%</b>
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	7,396,200.0	1,766,660.00	5,629,540.0	24%
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	12,966,950.43		
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	<b>17.00</b>	<b>17.00</b>	<b>-</b>	<b>100%</b>
620002	Гүйцэтгэх ажилтан	8.00	8.00	-	100%
620003	Үйлчлэх ажилтан	4.00	4.00	-	100%
620004	Гэрээт ажилтан	4.00	4.00	-	100%

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	22,631,057.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	22,631,057.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	227,057.00

<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	-	227,057.00
210702	Дотоод албан томилолт		227,057.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	-	22,404,000.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	-	22,404,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		22,404,000.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	-	<b>22,631,057.0</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	-	22,631,057.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	22,631,057.00

### 3. Аудитын тайлан

#### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Говь-Алтай аймгийн Гуулин тосгоны Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаатай холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Цэвэлмаа гүйцэтгэж, хяналтыг ахлах аудитор Ж.Бүжинханд, аудитын менежер Д.Эрдэнэчимэг, газрын дарга, тэргүүлэх аудитор Х.Түвшинбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Говь-Алтай аймгийн Гуулин тосгоны Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн 02 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

#### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Говь-Алтай аймгийн Гуулин тосгоны Эрүүл мэндийн төв нь үйлчлүүлэгчдэд ээлтэй сэтгэлд хүрсэн эмнэлгийн болон нийгмийн эрүүл мэндийн тусламжийг жигд хүртээмжтэй хүргэх чиг үүрэгтэй Гуулин тосгоны төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллага юм.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

#### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Говь-Алтай аймгийн Гуулин тосгоны Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 295.0 сая төгрөгөөс 2 хувиар буюу 5.9 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 4.7 сая төгрөгөөр тогтоосон.

Аудитын эрсдэл бага гэж үзэж тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг АДБОУС 2320-н 13-д заасны дагуу аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Говь-Алтай аймгийн Гуулин тосгоны Эрүүл мэндийн төвийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 23.1 хувиар буюу 72.2 сая төгрөгөөр өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Авлага дансны үлдэгдэл 52.6 сая төгрөг болж өссөн нь эрүүл мэндийн даатгалын сангаас авах санхүүжилтийн авлага байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 10.8 сая төгрөг болж 3.6 сая төгрөгөөр буурсан нь тайлант онд төсвийн хөрөнгөөр 70.7 сая төгрөгийн бараа материал бэлтгэж, хандиваар 68.4 сая төгрөгийн эм боох материал хүлээн авч, үйл ажиллагаандаа 141.5 сая төгрөгийн материалыг зарцуулж, 2.2 сая төгрөгийн материалыг үндсэн хөрөнгийн данс руу шилжүүлжээ. Тайлант оны бараа материалын эхний бодит үлдэгдэл нярвын тайлангаас нэр төрлөөр зөрүүтэй байсны улмаас дахин тооцоолол хийж 2.4 сая төгрөгийн эм боох материалыг орлого авч, 1.5 сая төгрөгийн бараа материалыг данснаас хассан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 451.7 сая төгрөг болж 17.9 сая төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 1.6 сая төгрөгийн хөрөнгө бэлтгэж, 19.2 сая төгрөгийн машин тоног төхөөрөмжийг аймгийн Эрүүл мэндийн газар, НҮБ-ийн хүүхдийн сан, бусад байгууллагаас үнэ төлбөргүйгээр хүлээн авч, 2.2 сая төгрөгийн хөрөнгийг бараа материалын данснаас шилжүүлэн авч, 5.0 сая төгрөгийн хөрөнгийг акталж, данснаас хассантай холбоотой байна.

Тайланд онд эм боох материал, сэлбэг хэрэгсэл, хоол хүнсний материалын худалдан авалтын 22.1 сая төгрөгийн өглөг үүссэн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 362.5 сая төгрөг болж 50.1 сая төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ. Орлого өмнөх оноос 59.6 хувиар буюу

175.9 сая төгрөгөөр өссөн нь үнэ төлбөргүй хүлээн авсан хөрөнгийн орлого, нэмэлт санхүүжилтийн орлого өссөнтэй холбоотой байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү хаасан бичилт хийгдээгүй ба тайлант оны хуримтлагдсан үр дүнгийн эцсийн үлдэгдэл -135.9 сая төгрөг болсон байна.

### **3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд урсгал зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 331.5 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсөв захирагчид хүргүүлсэн төсвийн төслөөс 21.2 сая төгрөгөөр бууруулж, 310.3 сая төгрөгөөр баталжээ. Төсвийн төсөл өмнөх оны батлагдсан төсвөөс бага байгаа нь нормативд зардал, бараа үйлчилгээний бусад зардлыг бууруулж баталсантай холбоотой байна.

#### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсөв захирагчийн 1 хөтөлбөрийн хүрээнд 4 арга хэмжээг тусгай зориулалтын шилжүүлэг, орон нутгийн төсөв, эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэхээр 310.3 сая төгрөгийн төсөв баталсан байна.

Гүйцэтгэлээр тусгай зориулалтын шилжүүлгээс 288.7 сая, орон нутгийн төсвөөс 14.1 сая, эрүүл мэндийн даатгалын сангаас 1.8 сая, нийт 304.6 сая төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 290.2 сая төгрөгийг зарцуулж 1.4 сая төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлж, 13.0 сая төгрөгийн мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэлтэй байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 290.2 сая төгрөг буюу 94 хувьтай байгаа нь байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 15.1 сая төгрөгөөр, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийг 2.1 сая төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 1.5 сая төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийг 0.7 сая төгрөгөөр тус тус хэмнэж зарцуулсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### **3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар 22.6 сая төгрөгийн орлого хүлээн авч, 22.4 сая төгрөгийг нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулалд, 0.2 сая төгрөгийг дотоод албан томилолтын зардалд зарцуулжээ.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тодорхойлсон тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй болно.

### 3.8 Аудитын гол асуудал

Тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасны дагуу тус байгууллагын 2021 оны Шилэн дансны хуулийн хэрэгжилт, худалдан авалтын и-баримтыг хяналаа.

#### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд Шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих 171 мэдээллээс 169 мэдээллийг хугацаандаа мэдээлсэн, 2 мэдээллийг хугацаа хоцорч мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

#### 3.9.2 Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн хэрэгжилт

Тайлант онд 4.5 сая төгрөгийн худалдан авалтын и-баримтыг дутуу шивүүлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7, Татварын ерөнхий хуулийн 28., 2-т " Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 14.3 дахь заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 2.3 сая төгрөгийн төлбөрийн акт, 16.7 сая төгрөгийн зөрчил арилгах албан шаардлага, 14.0 сая төгрөгийн 1 зөвлөмжийн шийдвэрийн хэрэгжилтийг хангуулсан байна. “Төрөөс эмийн талаар баримтлах бодлогын хэрэгжилт, үр нөлөө” гүйцэтгэлийн аудитын шийдвэрийн хэрэгжилт ирүүлэх хугацаа болоогүй байна.

### 3.11 ДАРААГИЙН АУДИТААР АНХААРАХ АСУУДАЛ

Дараагийн аудитаар эд хөрөнгийн тооллого, эм боох материалын зардал, эрүүл мэндийн даатгалын сангийн дутуу санхүүжилтээс үүссэн өр, авлагын барагдуулалтыг үзэх нь зүйтэй. Мөн нэмэлт санхүүжилтийн дансаар орж ирсэн 1.1 сая төгрөгийг оны эцэст буруу дансанд төвлөрүүлсэн асуудал байна.

#### 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 23.3 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 9.2 сая төгрөгийн алдааг залруулж, 0.3 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 13.8 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, 2 алдаа зөрчилд зөвлөмж өгсөн.

##### 4.1 Залруулсан алдаа

Үнэ төлбөргүй хүлээн авсан орлогыг 0.7 сая төгрөгөөр, үр дүнгийн тайланг 1.4 сая төгрөгөөр, бараа материалын тайланг 1.3 сая төгрөгөөр, төсвийн хэлбэлзлийг 0.6 сая төгрөгөөр, нэмэлт санхүүжилтийн орлогыг 1.0 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасныг аудитын явцад байгууллагын удирдлага, нягтлан бодогч хүлээн зөвшөөрч санхүүгийн тайланд залруулав. Зардлыг түүвэрлэн үзэхэд 4.1 сая төгрөгийн и-баримтгүй худалдан авалт хийсэн байсныг аудитын явцад нөхөж шивүүлсэн.

##### 4.2 Төлбөрийн акт

Тайлант онд 0.3 сая төгрөгийн шатахууныг жолоочийн тооцооны хуудасгүй, анхан шатны баримтгүй зарцуулсан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-т "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна.", 12.2-т "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ":, 12.2.1-т "жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө", 20 дугаар зүйлийн 20.2.6-т "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах"; Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.4-т "комиссын хурлаар тооллогын үр дүнг хэлэлцэж, тооллогын бүртгэлийг баталгаажуулж, холбогдох акт, материалын хамт ерөнхий нягтлан бодогчид тусгай жагсаалтаар шилжүүлэн өгөх" гэж заасныг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул төлбөрийн акт тогтоолоо.

##### 4.3 Албан шаардлага

Жилийн эцсийн хөрөнгийн тооллогын дүн санхүүгийн тайлангаас 3.3 сая төгрөгөөр зөрүүтэй, нягтлан бодогч тооцоо бодоогүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-т "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна.", 12.2-т "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ":, 12.2.1-т "жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө", 20 дугаар зүйлийн 20.2.6-т "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах"; Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.4-т "комиссын хурлаар тооллогын үр дүнг хэлэлцэж, тооллогын бүртгэлийг баталгаажуулж, холбогдох акт, материалын хамт ерөнхий нягтлан бодогчид тусгай жагсаалтаар шилжүүлэн өгөх" гэж заасныг зөрчсөн, оршин байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

Зардлыг түүвэрлэн үзэхэд 4.5 сая төгрөгийн и-баримтгүй худалдан авалт хийсэн нь Татварын ерөнхий хуулийн 28.2-т "Татвар төлөгч ногдуулалт хийхдээ энэ хуульд заасан нийтлэг журмыг баримтлах бөгөөд холбогдох хуульд заасны дагуу орлого, зарлагын гүйлгээг бүртгэх, баримтжуулах, цахим төлбөрийн баримт үйлдэх, хэвлэх, илгээх, татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд мэдээлэл дамжуулах зориулалт бүхий, нэгдсэн системд холбогдсон, стандартын шаардлага хангасан кассын машин, төхөөрөмж,

компьютер, бусад дагалдах хэрэгслийг зориулалтын дагуу бүрэн ашиглаж, борлуулалтын мэдээллийг 14 хоногт багтаан татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд илгээж, бүртгүүлнэ.", Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 14.3-т "Албан татвар суутган төлөгч хоорондын бараа борлуулсан, ажил гүйцэтгэсэн, үйлчилгээ үзүүлсэн тухай бүрд төлбөрийн баримт олгох бөгөөд уг баримтуудыг дангаар, эсхүл хамтатган нэмэгдсэн өртгийн албан татварын падаан үйлдэнэ" гэж заасныг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

Татварын тодорхойлолтоор 0.5 сая төгрөгийн илүү төлөлт татварын цахим системд бүртгэлтэй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ", 14.4.1-т "Аж ахуйн бүх ажил, гүйлгээ", 14.4.2-т "Бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага", 14.4.3-т "Бүх өр төлбөр" гэж заасныг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

Тайлант онд 0.4 сая төгрөгийн зардлын эдийн засгийн ангилал зөрчиж гүйлгээ хийсэн нь Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалыг зөрчсөн, үнэн зөв байх, толилуулга ба тодруулга, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

#### 4.4 Зөвлөмж

Аудитаар илэрсэн 2 алдаа, зөрчилд зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

##### 1. Үнэ төлбөргүй хүлээн авсан хөрөнгөтэй холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт: НҮБ-ийн Хүүхдийн сангийн "Ус хангамж, ариун цэвэр, эрүүл ахуйн хөтөлбөр"-өөр хийгдсэн хөрөнгө оруулалтын ажлыг данс бүртгэлд тусгаагүй байна. Өгсөн зөвлөмж: Төсвийн тухай хуулийн 25.7-т "Тусламж, хандивын орлогыг холбогдох журмын дагуу бүртгэж, гүйцэтгэлийг тайлагнана" гэж заасныг хэрэгжүүлж ажиллах

##### 2. Батлагдсан төсөв, зарцуулалттай холбоотой асуудал

##### 3. Нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой асуудал

3.1. Илрүүлэлт: Нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд шинэчлэгдэж батлагдсан анхан шатны маягтыг ашиглахгүй байна.

3.2. Өгсөн зөвлөмж: Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар батлагдсан НББ-ийн анхан шатны маягтыг ашиглах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Говь-Алтай аймгийн Дэлгэр сумын Гуулин тосгоны ЭМТ	9	23.3	2	9.2	1	0.3	4	13.8	2	0